

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ЭРХЛЭХ АСУУЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖИЖ БҮЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ  
БИЧИГ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД БУСАД БАРИМТ БИЧГҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮС**

**2026.03.27**

д/д	Баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Эрх зүйн актын дугаар	Хэрэгжих хугацаа	Хэрэгжилтийн явцын товч тайлбар (хувь, гол үр дүн, тулгамдсан асуудал)
Нэг. Монгол Улсын Шадар Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд					
1.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай	2020.05.13	УИХ-ын 52 дугаар тогтоол	2021-2030 он	Алтанбулаг чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын ажил нь Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 8.1.7 дугаар зорилтын хүрээнд хэрэгжиж байна. 2026 оны байдлаар дэд бүтцийн ажлын нийт гүйцэтгэл ойролцоогоор 20 хувьтай байна. Гаалийн хяналтын талбайн бүтээн байгуулалт хийгдсэн боловч инженерийн шугам сүлжээ, авто зам зэрэг үндсэн дэд бүтцийн ажлууд эхлээгүй байна. Төсвийн санхүүжилтийн тасалдал, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдын оролцоо сул байгаа зэрэг шалтгааны улмаас барилга байгууламжийг иж бүрэн ашиглалтад оруулах үйл явц удаашралтай байна. Иймд нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх, менежментийн тогтолцоог шинэчлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэх шаардлага үүссэн ба гадаадын донор байгууллагуудаас хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ авах, хамтын ажиллагааны боломжийг судлан ажиллаж байна.
2.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай	2020.08.28	УИХ-ын 23 дугаар тогтоол	2021-2025 он	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.1.5. чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт 2026 оны байдлаар дунджаар 20 орчим хувьтай байна. Дэд

					<p>бүтцийн инженерийн шугам сүлжээ, авто замын ажлын гүйцэтгэлд шаардлагатай төсөв, санхүүжилт бүрэн тусгагдаагүй байгаа нь бодлогын баримт бичгүүдэд туссан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хязгаарлаж байна. Мөн эрх зүйн зохицуулалтын уялдаа хангалтгүй, хөрөнгө оруулалтын тогтвортой орчны баталгаажуулалт шаардлагатай зэрэг тулгамдсан асуудлууд байсаар байна. Иймд төслийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор дэд бүтцийн санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт хэлбэрээр шийдвэрлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийн загварыг боловсронгуй болгох, хөрөнгө оруулагчдад чиглэсэн эрх зүйн орчны шинэчлэлийн санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх, хөрөнгө оруулалтын форум, уулзалтыг зохион байгуулах, гадаад, дотоодын стратегийн хөрөнгө оруулагчидтай хэлэлцээ эхлүүлэх зэрэг бодит арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх бэлтгэл ханган ажиллаж байна.</p>
3.	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	2024.08.27	УИХ-ын 21 дүгээр тогтоол	2024-2028 он	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 132, 133, 134, 538, 545, 546, 547 дугаар зорилт арга хэмжээний хэрэгжилт 2026 оны байдлаар дунджаар 20 орчим хувьтай байна.</p> <p>Авто замын шинэчилсэн зураг төсөл, магадлал, төсөв батлагдсан, ерөнхий төлөвлөгөө экспертизийн шатанд хүрсэн зэрэг суурь бэлтгэл ажлууд хангагдаж, төслийг дараагийн шатанд шилжүүлэх техникийн үндэс бүрдээд байна.</p> <p>Барилгын материалын логистикийн төв байгуулах суурь баримт бичиг боловсруулах 128.0 сая төгрөг, авто замын барилга угсралтын ажлын 71.16 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнчлэн холбогдох ТЭЗҮ, зураг төслийн зардал улсын</p>

					<p>төсөвт тусгагдаагүй, ерөнхий төлөвлөгөө эцэслэн батлагдаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын төслүүдийн бодит хэрэгжилтийг хойшлуулах нөхцөл үүсгээд байна. Үүний улмаас шинэ төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа түр хугацаанд зогсоод байна.</p> <p>Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт хэлбэрээр шийдвэрлэх санал боловсруулж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн загварын хүрээнд хэрэгжүүлэх боломжийг судлан, холбогдох байгууллагуудтай уялдуулах, хөрөнгө оруулагчидтай урьдчилсан уулзалт хийх зэрэг бэлтгэл ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.</p>
4.	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай	2024.10.18	УИХ-ын 35 дугаар тогтоол	2025 он	<p>Монгол Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан 2.1.2.2., 2.1.2.4. зорилт арга хэмжээний хэрэгжилт 2026 оны байдлаар дунджаар 20 хувьтай байна.</p> <p>Авто замын шинэчилсэн зураг төсөл, магадлал, төсөв батлагдсан, ерөнхий төлөвлөгөө боловсруулалтын шатанд үргэлжилж байна.</p> <p>Авто замын барилга угсралтын ажлын санхүүжилт улсын төсөвт бүрэн тусгагдаагүй, барилгын материалын логистикийн төвийн суурь баримт бичгийн зардал шийдвэрлэгдээгүй, ерөнхий төлөвлөгөө эцэслэн батлагдаагүй байгаа нь бодит бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх боломжийг хязгаарлаж, төслийн хэрэгжилтийн хурдыг удаашруулж байна.</p> <p>Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр авто зам, дэд бүтцийн санхүүжилтийг улсын төсөвт тусгуулах санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлээд байна. Мөн барилгын материалын логистикийн төвийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэх</p>

					<p>боломжийг судалж, хөрөнгө оруулагчдын урьдчилсан сонирхлыг татах арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ханган ажиллаж байна. Ерөнхий төлөвлөгөөг эцэслэн батлуулах чиглэлээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Барилга хөгжлийн төв ТӨҮГ-тай уялдаа ханган ажиллаж байна.</p>
<p>Хоёр. Монгол Улсын Шадар Сайдын эрхлэх асуулын хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжиж буй УИХ, Засгийн газраас батлагдсан бусад баримт бичгүүд, Шадар Сайдын тушаалаар батлан салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй бодлогын асуудал зохицуулсан тушаал шийдвэр (хөтөлбөр стратеги төлөвлөгөө)</p>					
1.	Алтанбулаг чөлөөт бүсийн Стратеги төлөвлөгөө 2025-2028 он	2025.08.27	Монгол Улсын Шадар Сайд баталсан.	2025-2028 он	<p>Алтанбулаг чөлөөт бүсийн 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2026 оны байдлаар дунджаар 20 орчим хувьтай байна. Тусгай зөвшөөрлийн журмын шинэчлэлийн төсөл боловсруулагдаж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө экспертизийн шатанд хүрсэн, 0.81 км авто замын барилгын ажлын суурь бэлтгэл хангагдсан, гадаад хамтын ажиллагааны хүрээнд санамж бичиг байгуулах урьдчилсан бэлтгэл ажлууд хийгдэж байна.</p> <p>Мөн бараа эргэлт, зорчигч тээврийн статистик бүртгэлийн тогтолцоог сайжруулах зорилгоор ухаалаг орц, гарцын системийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа нь стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд бодит ахиц авчирч байна.</p> <p>Стратеги төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн барилга угсралтын санхүүжилт улсын төсөвт бүрэн тусгагдаагүй, ерөнхий төлөвлөгөө эцэслэн батлагдаагүй, хөрөнгө оруулагчдын оролцоо хязгаарлагдмал, зэрэг тулгамдсан асуудлууд байсаар байна. Иймд холбогдох байгууллагуудтай уялдуулан санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх, ерөнхий төлөвлөгөөг эцэслэн баталгаажуулах, хөрөнгө</p>

					<p>оруулагчидтай урьдчилсан уулзалт хийх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэх зэрэг арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангаж байна.</p>
2.	<p>Моногл Улсын Шадар Сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр</p>	2025.02.14	<p>Моногл Улсын Шадар Сайдын 25 дугаар тушаал</p>	2025-2028 он	<p>Монгол Улсын Шадар Сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Стратеги зорилт арга хэмжээний 10, 12, 15 дахь хэсэгт заагдсан Алтанбулаг чөлөөт бүс болон бусад чөлөөт бүсүүдийн хууль эрх зүйн орчныг сайжруулах, ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, судалгааг боловсронгуй болгож, логистикийн төв болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажил нь 20 хувийн гүйцэтгэлтэй байна. Шадар сайдын 2025 оны 96 дугаар тушаалаар байгуулагдсан Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсэг нь батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж чөлөөт бүсийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар санал боловсруулан Шадар Сайдын ажлын албанд хүргүүлсэн. Мөн барилгын материалын логистикийн төв байгуулах суурь баримт бичиг боловсруулах 128.0 сая төгрөг, авто замын барилга угсралтын ажлын 71.16 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнчлэн холбогдох ТЭЗҮ, зураг төслийн зардал улсын төсөвт тусгагдаагүй, ерөнхий төлөвлөгөө эцэслэн батлагдаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын төслүүдийн бодит хэрэгжилтийг хойшлуулах нөхцөл үүсгээд байна. Үүний улмаас шинэ төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа түр хугацаанд зогсоод байна.</p>

					<p>Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт хэлбэрээр шийдвэрлэх санал боловсруулж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн загварын хүрээнд хэрэгжүүлэх боломжийг судлан, холбогдох байгууллагуудтай уялдуулах, хөрөнгө оруулагчидтай урьдчилсан уулзалт хийх зэрэг бэлтгэл ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.</p>
--	--	--	--	--	---